

**АНУ-ЫН 117 ДУГААР КОНГРЕССЫН СЕНАТЫН ТАНХИМЫН
36 ДУГААР ТОГТООЛ**

*Америкийн Нэгдсэн Улс, Монгол Улсын Стратегийн түншлэлийг бататгах,
Монгол Улс дахь ардчилсан тогтолцооны 30 жилийн ойг тэмдэглэх тухай*

Америкийн Нэгдсэн Улс болон Монгол Улс нь 1987 оны нэгдүгээр сард дипломат харилцаа тогтоосон бөгөөд тэр цагаас хойш хоёр талын харилцаа стратегийн нийтлэг ашиг сонирхол, аюулгүй байдлын төлөөх хамтын ажиллагаа, ардчилсан үнэт зүйлс, сайн засаглал, хүний эрхийг дээдлэх зарчимд тулгуурлан улам бүр бэхэжсээр ирсэн;

Монгол Улс нь 1989 онд тайван замаар ардчилсан хувьсгал өрнүүлснээсээ хойш удаа дараагийн санаачилга гаргаж, олон намын тогтолцоо бүхий ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийг байгуулах замналаа амжилттайгаар эхлүүлсэн;

Монгол Улсын Засгийн газар 1990 онд нэг намын, авторитар улс төрийн тогтолцоог халж, ардчилсан, чөлөөт зах зээлийн шинэчлэлд шилжин орсон;

Монгол Улс 1992 онд ардчиллыг хуульчлан тогтоосон Үндсэн хууль баталж, коммунизмаас ардчилалд шилжсэн Ази тивийн анхны улс болсон;

Монгол Улс нь 2003 оноос 2008 оны хооронд Ирак Улс, 2009 оноос хойш Афганистан Улсад АНУ-ын явуулж буй ажиллагаанд цэрэг илгээж АНУ-тай тогтоосон “гуравдагч хөрш”-ийн харилцаандаа тууштай байгаагаа нотолсон. Түүнчлэн Монгол Улс олон улсын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг дайчдаа олноор нь илгээж идэвхийлэн оролцдог;

Монгол Улсын үе үеийн Засгийн газар иргэний нийгмийг бэхжүүлэх, авилгатай тэмцэх, эдийн засгийн хөгжлийг түргэсгэх чиглэлд тэмдэглүүштэй алхмуудыг авч хэрэгжүүлсэн;

Монгол Улсын парламент болох Улсын Их Хурал нь АНУ-ын Конгресстой Төлөөлөгчдийн Танхимын Ардчиллын төлөөх түншлэлийн хүрээнд хамтран ажиллах зэргээр парламент хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хариуцлагатай, үр дүнтэй засаглалыг дэмжиж ирсэн,

Монгол Улс нь 2004 онд Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын /ЕАБХАБ/ түнш орон болж, улмаар 2012 онд бүрэн эрхт гишүүн болон дэвшиж, тогтвортой байдал, энх тайван, ардчиллыг дэмжих хүрээнд ЕАБХАБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн;

Монгол Улс нь Ерөнхийлөгч, парламентын сонгуульдаа ЕАБХАБ болон олон улсын бусад байгууллагын ажиглагч, төлөөлөгч нарыг тогтмол урьдаг;

Монгол Улс нь ардчиллын нийтлэг үнэт зүйлс, жишгийг сахин хамгаалагч дэлхий нийтийн эвсэл болох Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгт /АОХН/, 2000 онд байгуулагдсан цагаас нь хойш идэвхтэй гишүүн байсаар ирсэн төдийгүй уг эвслийг 2011-2013 онд амжилттай даргалсан;

Монгол Улс нь ЕАБХАБ, АОХН-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ ардчиллын төлөөх дэлхий нийтийн бусад институт, санаачилгад нэгдэж, дэмждэг;

Монгол Улс нь саяхан буюу 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдөр парламентын сонгуулиа амжилттай зохион байгуулж, ардчилал, хууль дээдлэх ёсны төлөөх тууштай байдлаа баталгаажуулсан;

Ардчилсан Монгол Улс, түүний стратегийн ач холбогдол бүхий байрлал, тусгаар тогтнол, газар нутгийн халдашгүй байдал, бие даасан гадаад бодлого хэрэгжүүлэх чадвар нь АНУ-ын үндэсний аюулгүй байдалд ихээхэн ач холбогдолтой;

АНУ нь Мянганы сорилтын корпорацаараа дамжуулан эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах зорилгоор 2007 онд гарын үсэг зурсан эхний компакт гэрээ, усан хангамж, бохир усыг дахин боловсруулах, усны салбарын тогтвортой байдлыг хангах зэргээр усны дэд бүтцэд хөрөнгө оруулсан 2018 оны хоёр дахь компакт гэрээний хүрээнд Монгол Улсад тусламж үзүүлж байна;

АНУ болон Монгол Улс нь 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хамтарсан мэдэгдэл, Эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглалыг батлан, үүгээрээ 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Нью-Йорк хотноо гарын үсэг зурсан Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай АНУ, Монгол Улс хоорондын хэлэлцээр /Оршил хэсэгт “АНУ-Монгол Улс хоорондын ил тод байдлын хэлэлцээр” хэмээн дурдсан/-ийн дагуу хүлээсэн үүрэг, амлалтаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, Монголын жижиг, дунд үйлдвэрийг төрөл бүрийн хөтөлбөр, төслөөр дамжуулан дэмжих чиглэлд хамтран ажиллах замаар хоёр талын худалдааны харилцааг гүнзгийрүүлэх эрмэлзлээ нотолсон;

АНУ-ын Тооллогын товчооны мэдээллээр АНУ, Монгол Улс хоорондын худалдаа хязгаарлагдмал хэдий ч өсөн нэмэгдэх үзүүлэлттэй байгаа ба 2019 оны байдлаар хоёр орны худалдааны нийт эргэлт ойролцоогоор 217,400,000 сая ам.доллар, үүнд АНУ-аас Монгол Улс руу хийсэн экспорт 192,800,000 сая ам.доллар, Монгол Улсаас АНУ-руу хийсэн импорт 24,600,000 сая ам.доллар байна;

Монгол Улс нь Хөнгөлөлтийн Ерөнхий Систем /GSP/-ийн хөтөлбөрт хамрагддаг улс хэдий ч тус хөтөлбөрийг бага ашиглаж байгаа бөгөөд 2018 онд тус хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсаас АНУ-руу ердөө 3,200,000 ам.долларын экспорт хийсэн байна;

2019 оны долдугаар сарын 31-ний өдөр АНУ, Монгол Улс хоорондын хоёр талын харилцааг “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэснээ тунхаглан дараах хамтын эрмэлзлийг тэмдэглэсэн болно. Үүнд:

(1) хууль дээдлэх зарчимд тулгуурлан, бэхэжсэн ардчилсан тогтолцоо бүхий улсууд болохынхоо хувьд ардчилсан үнэт зүйлс, хүний эрх, тэр дундаа шашин шүтэх, эс

шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх, интернет ашиглах, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хамгаалж, хөхиүлэн дэмжих, авилгатай тэмцэх, санхүүгийн ил тод байдлыг хангах, залуу, шинэ үеийн манлайлагчдыг хөгжүүлэх чиглэлд хамтын ажиллагааг эрчимжүүлэх;

(2) Бүрэн эрхээ баталгаажуулсан бүх улс орон шударга өрсөлдөөний олон улсын эрх зүйн зарчмуудад нийцүүлэн эдийн засгийн хөгжлийнхөө замаар итгэлтэй замнах боломжийг бүрдүүлэхийн тулд Энэтхэг-Номхон далайн бүс нутаг даяар үндэсний аюулгүй байдал, тогтвортой байдлыг сайжруулах чиглэлд хамтран ажиллах;

(3) Тус бүс нутаг дахь аюулгүй байдал, шүүх засаглал, хууль сахиулах чиглэлээрх хоёр ба олон талт хүчин чармайлтуудыг дэмжиж хамтран ажиллах замаар үндэсний аюулгүй байдал, хууль сахиулах чиглэлийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх;

(4) Энхийг сахиулах ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж, гамшгийн бэлэн байдал, гамшгийн үр дагаврыг арилгах зэрэг олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх;

(5) худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг шударга, харилцан ашигтай байх зарчимд үндэслэн өргөжүүлэх, хувийн хэвшилд суурилсан өсөлтийг дэмжих, АНУ, Монгол Улс хоорондын Ил тод байдлын хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, 2018 оны Хөгжлийн төлөөх хөрөнгө оруулалтыг хүртээмжтэй ашиглах тухай хуулийн /BUILD Act/ хүрээнд бий болж буй эрх зүйн шинэ хэрэгслүүдийг ашиглан АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацын шугамаар дэд бүтцийг дэмжих боломжийг үргэлжлүүлэн эрэлхийлэх;

(6) хилийн аюулгүй байдлыг бэхжүүлж, хууль бусаар шилжүүлэн ачих, тээвэрлэхээс урьдчилан сэргийлж, иргэний нисэхийн аюулгүй байдал, хяналт шалгалтын чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэн, Монгол Улс, АНУ хооронд хууль ёсны дагуу зорчих, тээвэрлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах;

(7) терроризм, хүний наймаа, мансууруулах бодисын наймаа, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, цахим халдлага, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, цар тахал, урьд өмнө үзэгдээгүй буюу шинээр гарч ирж буй аюул заналтай тэмцэх чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх;

(8) иргэний нийгэм, нийгмийн сүлжээ, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэл цэцэглэн хөгжих таатай орчныг үргэлжлүүлэн хөгжүүлэх;

(9) харилцан сонирхож буй асуудлын талаар уялдаа холбоог гүнзгийрүүлэх зорилгоор өндөр түвшний албан ёсны яриа хэлэлцээг тогтмолжуулах, Засгийн газрын бүх түвшинд хоёр талын харилцан айлчлалыг хөхиүлэн дэмжих, ард иргэд хоорондын харилцааг хөгжүүлэх зэрэг болно.

Дээрхийг бататган, Сенатын танхим доор дурдсан тогтоолыг гаргаж байна. Үүнд:

(1) АНУ, Монгол Улсын харилцааны ач холбогдлыг онцлон тэмдэглэж, энэхүү Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэхийн төлөө байна;

(2) Монгол Улс дахь чөлөөт, шударга сонгуулийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж байна;

(3) Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/, Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг, конгресс-парламент хоорондын түншлэл, түүний дотор дээд, өндөр түвшний харилцан айлчлал, Монгол Улсын Засгийн газар болон ард түмний ардчиллын үнэт зүйлс, стандартын төлөөх тууштай байдлыг бататган тодорхойлдог, эдгээр үнэт зүйлсийг хөхиүлэн дэмждэг бусад байгууллагуудын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцож буйг сайшааж байна;

(4) АНУ, Монгол Улсын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Хөнгөлөлтийн ерөнхий систем болон бусад холбогдох хөтөлбөрийн /GSP/ хүрээнд Монгол Улсад олгож буй давуу байдлыг ашиглахад нь дэмжлэг үзүүлэхийг АНУ-ын Засгийн газарт уриалж байна;

(5) Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээрх үйл ажиллагаагаа өргөжүүлэхийг АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацид уриалж байна;

(6) хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэд бүтэц болон бусад чухал төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг төр, хувийн хэвшилд уриалж байна;

(7) Монгол Улсын ардчилал, эдийн засгийн хөгжил, авлигын эсрэг хүчин чармайлтыг үргэлжлүүлэн дэмжихийг АНУ-ын Төрийн департамент, Олон улсын хөгжлийн агентлаг болон бусад холбогдох байгууллагуудад уриалж байна;

(8) Монгол Улсын ардчилсан хөгжил тасралтгүй явагдахад иргэний нийгмийн ач холбогдлыг дахин нотолж байна;

(9) бие даасан төрийн бус байгууллагуудын өсөлт, үйл ажиллагааг дэмжих, ардчиллын үнэт зүйлийг эрхэмлэсэн ил тод байдлын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зохицуулалтын тогтолцоог бий болгохыг Монгол Улсын Засгийн газарт уриалж байна;

(10) эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлэх, институцийн чадавхыг бэхжүүлэх, бусад ардчилсан байгууллагуудын хараат бус байдлыг сайжруулахыг Монгол Улсын Засгийн газарт уриалж байна.